



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар A/236.

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Засгийн газрын 2018 оны 40 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх журам”-ыг нэгдүгээр, “гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх маягт 1”-ийг хоёрдугаар, “гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх маягт 2”-ыг гуравдугаар, “гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх маягт 3”-ыг дөрөвдүгээр, “гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх маягт 4”-ийг тавдугаар, “хяналт шалгалт хийсэн илтгэх хуудас бичих загвар”-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх журам”-ыг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга, захирагч наарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажиллагааны удирдлагын газар (хурандаа А.Дашням)-т даалгасугай.

4. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

1425011815

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны дугаар сарын 1-ны өдрийн
тушаалын... дүгээр хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч, гэрээт байцаагч (цаашид "байцаагч" гэх) нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж, шийдвэрийн биелэлтийг хангуулах, хяналт тавих, дүгнэх, мэргэжил, арга зүйн заавар, зөвлөмж өгөх, үүрэг хариуцлагыг сайжруулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журам нь байцаагчийн эрхтэй Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Ажиллагааны удирдлагын газар, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга нараас бусад байцаагчийн эрхтэй албан тушаалтанд хамаарна.

Хоёр. Зохион байгуулалт

2.1. Аймаг, нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын давтамж, цар хүрээ, дэд бүтэц, иргэн, хуулийн этгээдийн статистик тоон мэдээллийг үндэслэн гамшгаас хамгаалах улсын хяналтыг үйлчлэх хүрээгээр нь дөрвөн зэрэглэлд хувааж үзнэ. Үүнд:

2.1.1. нэгдүгээр зэрэглэлд: Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Төв, Сэлэнгэ, Ховд аймаг, нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг;

2.1.2. хоёрдугаар зэрэглэлд: Архангай, Говь-Алтай, Дорнговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Увс, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэлийн Багануур, Налайх дүүрэг;

2.1.3. гуравдугаар зэрэглэлд: Булган, Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар аймаг, нийслэлийн Багахангай дүүрэг;

2.1.4. дөрөвдүгээр зэрэглэлд: 09 дүгээр анги, Төрийн ордон болон тусгай объектуудыг гамшгаас хамгаалах тасаг, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын цацраг, хими, тэсэрч дэлбэрэх бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн, гэрээт Гал түймэр унтраах, аврах 58 дугаар ангийн байцаагч тус тус харьяалагдана.

Гурав. Хяналт шалгалтын хамрах хүрээ

3.1. Байцаагч сар тутамд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг иргэн, хуулийн этгээдэд хийж, байцаагчийн албан шаардлагаа, мэдэгдэл, дүгнэлт, акт, зөвлөмж үйлдэж, биелэлтэд хяналт тавина. Үүнд:

3.1.1. нэгдүгээр зэрэглэлд 20-оос доошгүй иргэн, хуулийн этгээдийг хамруулж, 80 хувьд;

3.1.2.хоёрдугаар зэрэглэлд 15-аас доошгүй иргэн, хуулийн этгээдийг хамруулж, 70 хувьд;

3.1.3.гуравдугаарр зэрэглэлд 10-аас доошгүй иргэн, хуулийн этгээдийг хамруулж, 60 хувьд;

3.1.4.дөрөвдүгээр зэрэглэлд 5-аас доошгүй иргэн, хуулийн этгээдийг хамруулж, 50 хувьд эрх зүйн баримт бичиг тус тус үйлдэнэ.

3.2.Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд гүйцэтгэж, 80-аас доошгүй хувьд нь гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулна.

3.3.Иргэн, хуулийн этгээдийн тоо журмын 3.1-т заасан тоонд хүрээгүй тохиолдолд холбогдох судалгааг үндэслэн, шалгавал зохих байгууллагын тоог багасгаж болох бөгөөд судалгааг маягтад хавсарган ирүүлнэ.

3.4.Байцаагчийн үүргийг давхар гүйцэтгэж байгаа төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын алба хаагч нарын хяналт шалгалтын дундаж үзүүлэлтийг 50 хувиар тооцно.

3.5.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын хэрэг, зөрчил, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, санал хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, бүртгэл хөтөлнө.

3.6.Гамшгаас хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ажиллагааг тухай бүр хийж, зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг харьяа прокурорын байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж, хянуулна.

3.7.Цацраг, хими, тэсэрч дэлбэрэх бодисын импорт, тээвэрлэлтийн үеийн төлөвлөлтөд хяналт тавьж, баталгаажуулна.

Дөрөв. Бүртгэл, судалгаа

4.1.Байцаагч нь үйл ажиллагаандаа дараах бүртгэл, судалгааг хөтөлнө. Үүнд:

4.1.1.төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтын материал;

4.1.2.байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн бүртгэл;

4.1.3.зөрчил шалган шийдвэрлэсэн материалын бүртгэл;

4.1.4.гамшиг, аюулт үзэгдэл ослын бүртгэл, судалгаа;

4.1.5.иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, бүртгэл, материалыг тус тус хөтөлнө.

Тав. Дүгнэх хугацаа, аргачлал

5.1.Байцаагч нь тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг сар, улирал, жилээр төлөвлөж, мэдээ тайланг сар бүр гаргана.

5.1.1.энэхүү журмын 3 дугаар зүйлд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрийн дотор төв, орон нутгийн онцгой байдлын газрын дарга, захирагчаар баталгаажуулан Ажиллагааны удирдлагын газарт ирүүлнэ.

5.1.2.ирүүлсэн тайланг Гамшгаас хамгаалах улсын хяналт хариуцсан бүтцийн нэгж сар, улирал, хагас жил, бүтэн жилээр нэгтгэн дүгнэж баталгаажуулна.

5.2.Байцаагчийн ажлыг дараах аргачлалаар дүгнэнэ. Үүнд:

5.2.1."төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт"-ыг тооцоходо шалгавал зохих байгууллагын тооноос шалгасан байгууллагын тоог харьцуулан хувилж, 20 хүртэлх оноогоор дүгнэнэ. (1 дүгээр хүснэгт)

5.2.2."гүйцэтгэлийн хяналт шалгалт"-ыг тооцоходо байцаагчаас гарсан эрх зүйн баримт бичиг гаргасан байгууллагын 80 хувьд нь гүйцэтгэлийн шалгалт хийснээр хувилж, 10 хүртэлх оноогоор дүгнэнэ. (2 дугаар хүснэгт)

5.2.3."зөрчил"-ийг тооцоходо илрүүлсэн зөрчлөөс гүйцэтгэлийн хяналт шалгалтаар арилгуулсан зөрчлийг хувилж, 10 хүртэлх оноогоор дүгнэнэ. (3 дугаар хүснэгт)

5.2.4."байцаагчаас гаргасан эрх зүйн баримт бичиг"-ийг тооцоходо шалгасан байгууллагын тоог журмын 3.1 дэх заасны дагуу хувилж, 10 хүртэлх оноогоор дүгнэнэ. (4 дүгээр хүснэгт)

5.2.5."зөрчил шалган шийдвэрлэсэн байдал"-ыг тооцоходо биелэлтийн шалгалтаар зөрчлөө арилгаагүй болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан байдлыг 20 оноогоор дүгнэнэ. (5 дугаар хүснэгт)

5.2.6.үндсэн 5 хүснэгтийн нийлбэр оноог тооцоходо хүснэгт 1-5-ын оноог нэмж тооцно.

5.2.7."бусад ажил, нэгдсэн арга хэмжээ"-г тооцоходо журмын 3.7 дахь заалтыг хэрэгжүүлсэн болон үндсэн чиг үүрэгтэй холбоотой нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхтэй оролцсон байцаагчийг 10 хүртэлх оноогоор дүгнэнэ. (6 дугаар хүснэгт)

5.2.8."мэдээ, тайлан ирүүлсэн байдал"-ыг тооцоходо холбогдох мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлснээр хувилж, 20 хүртэлх оноогоор дүгнэнэ. (7 дугаар хүснэгт)

5.3.Байцаагчийн сард хийсэн ажлыг нэгтгэн тооцоходо батлагдсан маягтын 1-5 дугаар хүснэгтийн дундаж оноо дээр хүснэгт 6, хүснэгт 7-гийн оноог нэмж дүгнэнэ.

5.4.Байцаагчийн сард хийсэн ажлын дундаж хувьд дүйцүүлэн дараах үнэлгээг олгоно. Үүнд:

90-100 хувь "A" буюу "Маш сайн";

80-89 хувь "B" буюу "Сайн";

70-79 хувь "C" буюу "Хангалттай";

60-69 хувь "D" буюу "Дутагдалтай";

0-59 хувь "F" буюу "Хангалтгүй";

5.5.Байцааг нь сарын дундаж үзүүлэлтээс илүү иргэн, хуулийн этгээдэд хяналт шалгалт хийсэн болон дуудлага, мэдээллийн дагуу үүрэг гүйцэтгэсэн, цацраг, хими, тэсэрч дэлбэрэх бодисын ослын үеийн болон тээвэрлэлтийн төлөвлөгөө хянасан, гамшгийн голомт (уул уурхай, хүн малын гоц халдварт өвчин, халиа, дошин, үер)-д гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлсэн байдал нь тухайн алба хаагчийн жилийн үнэлгээг тооцоход 5 хүртэлх оноог нэмэгдүүлж болно.

Зургаа. Хариуцлага

6.1.Ажиллагааны удирдлагын газар байцаагч нарын ажлыг жилийн эцэст нэгтгэн дүгнэж байр эзлүүлнэ.

6.2.Жилийн эцсийн дүнгээр "маш сайн" дүгнэгдсэн алба хаагчдыг урамшуулах, "хангалтгүй" дүгнэгдсэн алба хаагчдад хариуцлага тооцох саналыг Онцгой байдлын өрөнхий газрын дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын өрөнхий байцаагчид уламжлан шийдвэрлүүлнэ.

---оOо---

Онцгой байдалын ерөнхий газарын даргын
2025 оны дугаар сарын 17-ны өдрийн
дугаар тушаалын дугаар хавсралт


ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
АЖИЛ ДҮГНЭХ МАЯГТ 1 (НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛ)

| Хяналт, шалгалт | | Төрийн хяналт, шалгалт | | Сард хийсэн ажлын үзүүлэлт | |
|------------------------------|----------------------------------|------------------------|--|---|---|
| 20 ондоо | 10 ондоо | 10 ондоо | 10 ондоо | 20 ондоо | 20 ондоо |
| Аймаг, нийслэл ийн нэр | Байцаагч ийн цол, овог нэр | Зөрчил | Байцаагчийн эрх зүйн баримт бичиг (80 хувь буюу 16) | Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал | Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал |
| НОБГ | х/ч Б.Бат | 17 | 10 | 7.3 | 8 |
| Оноо | | | | 20 | 20 |
| | | | | 62.3 | 62.3 |
| | | | | 8 | 8 |
| | | | | 15 | 15 |
| | | | | 85 | 85 |
| | | | | В | В |

ДҮГНЭСЭН:

ДАРГА, /.....
Байгууллагын нэр
(цол, гарын үсэг)
(огноо) /.....

/.....
(гарын үстийн тайпал)
(огноо) /.....



Онцгой байдлын өрөнхий газрын даргын
2025 оны 22-ны өдрийн
дугаар тушаалын дугаар хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
АЖИЛ ДҮГНЭХ МАЯГТ 2 (ХОЁРДУГААР ЗЭРЭГЛЭЛ)**

| | | Сард хийсэн ажлын үзүүлэлт | | | | | | | | | |
|------------------------------|-------------------------------------|---|---|---|---|--|---|--|---|---|----------|
| | | Төрийн хяналт, шалгалт | | | | | | | | | |
| Аймаг, нийслэл ийн нэр | Байцааг чийн цол, овог нэр | Хяналт, шалгалт | | Зөрчил | | Байцаагчийн эрх зүйн баримт бичиг (70 хувь буюу 10) | | Зөрчил шалган шиийдвэрлэсэн байдал | | Үзүүлэлт | |
| | | 20 ондоо | 10 ондоо | 10 ондоо | 10 ондоо | 10 ондоо | 20 ондоо | 10 ондоо | 10 ондоо | 20 ондоо | Үзүүлэлт |
| | | | | | | | | | | | |
| | | Xybp (оноо) | Xybp (оноо) | Xybp (оноо) | Xybp (оноо) | Xybp (оноо) | |
| | | Лицензийн уулзаж авсан хувь (80%) | Лицензийн уулзаж авсан хувь (80%) | Лицензийн уулзаж авсан хувь (80%) | Лицензийн уулзаж авсан хувь (80%) | Лицензийн уулзаж авсан хувь (80%) | |
| | | Лицензийн уулзаж авсан хувь (60%) | Лицензийн уулзаж авсан хувь (60%) | Лицензийн уулзаж авсан хувь (60%) | Лицензийн уулзаж авсан хувь (60%) | Лицензийн уулзаж авсан хувь (60%) | |
| | | Лицензийн уулзаж авсан хувь (40%) | Лицензийн уулзаж авсан хувь (40%) | Лицензийн уулзаж авсан хувь (40%) | Лицензийн уулзаж авсан хувь (40%) | Лицензийн уулзаж авсан хувь (40%) | |
| | | Лицензийн уулзаж авсан хувь (20%) | Лицензийн уулзаж авсан хувь (20%) | Лицензийн уулзаж авсан хувь (20%) | Лицензийн уулзаж авсан хувь (20%) | Лицензийн уулзаж авсан хувь (20%) | |
| | | Лицензийн уулзаж авсан хувь (10%) | Лицензийн уулзаж авсан хувь (10%) | Лицензийн уулзаж авсан хувь (10%) | Лицензийн уулзаж авсан хувь (10%) | Лицензийн уулзаж авсан хувь (10%) | |
| | | Лицензийн уулзаж авсан хувь (5%) | Лицензийн уулзаж авсан хувь (5%) | Лицензийн уулзаж авсан хувь (5%) | Лицензийн уулзаж авсан хувь (5%) | Лицензийн уулзаж авсан хувь (5%) | |
| | | Хүчинт 1 | | Хүчинт 2 | | Хүчинт 3 | | Хүчинт 4 | | Хүчинт 5 | |
| НОБГ | ХЧ Б.Бат | 15 | 8 | 1 | 2 | 73 | 5 | 100 | 45 | 2 | 62 |
| Оноо | | 14.6 | | | | 10 | | | 6.2 | - | - |
| | | | | | | | | | 6.5 | | 6.5 |
| | | | | | | | | | | | |

ДҮГНЭСЭН:
..... ДАРГА, /.....
Байгууллагын нэр
(цол, гарын үсэг)

(отноо) /.....
(гарын үсгийн тайлап)
/.....



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны дугаар сарын 22-ны өдрийн
дугаар тушаалын дүгээр хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
АЖИЛ ДҮГНЭХ МАЯГТ 3 (ГУРАВДУГААР ЗЭРЭГЛЭП)**

| Сард хийсэн ажлын үзүүлэлт | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|----------------------------------|---|--------------------------------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|---|---|---|---|---|-----|----|-----|-----------|
| Хамгаалалт, шалгалаат Төрийн хяналт, шалгалаат | Зөрчил | Байцаагчийн эрх зүйн баримт бичиг (60 хувь буюу 6) | Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | 20 ондоо | 10 ондоо | 10 ондоо | 20 ондоо | 20 ондоо | 70 ондоо | 10 ондоо | 20 ондоо | Үзүүлэлт | | | | | | | | | |
| Аймаг, нийслэл ийн нэр | Байцаагч ийн цол, овог нэр | | | | | | | | | | | | | | | | | | | |
| НОБГ | ХЧБ.Бат | 10 | 5 | 2 | 1 | 80 | 3 | 75 | 40 | 2 | 60 | - | 2 | 2 | 1 | - | 78 | 1 | 100 | Хүснэгт 5 |
| | Оноо | 16 | 16 | 7.5 | 6 | 6 | | 7.5 | 4 | 6 | | | | | | | 7.8 | 20 | 20 | Хүснэгт 1 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | Хүснэгт 2 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | Хүснэгт 3 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | Хүснэгт 4 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | Хүснэгт 5 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | Хүснэгт 6 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | Хүснэгт 7 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | Хүснэгт С |

ДҮГНЭСЭН:

ДАРГА, /...../
(цол, гарын үсэг)
(огноо) /...../
Байгууллагын нэр
(гарын үстийн тайлал)

/...../
(огноо) /...../

Онцгой байдлын ерөнхий газрын дарын
2025 оны дугаар сарын 27-ны өдрийн
дугаар тушаалын 22 дугаар хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
АЖИЛ ДҮГНЭХ МАЯГТ 4 (ДӨРӨВДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛ)**

| | | Сард хийсэн ажлын үзүүлэлт | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|------------------------------|----------------------------------|----------------------------|---|---|--------------|-----------|-----------|-----------|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|
| | | Төрийн хяналт, шалгалт | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Аймаг, нийслэл ийн нэр | Байцаагч ийн цол, овог нэр | Хяналт, шалгалт | Зэрчил бичиг (50 хувь буюу 2) | Зерчил шалган шийдвэрлэсэн байдал | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | 20 ондоо | 10 ондоо | 10 ондоо | 20 ондоо | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Xybp (ohoo) | AlU | Xybp (ohoo) | Xybp (ohoo) | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Apniryyircach | M3A3RA3n | 3eBtremk | XAAh hark3ap | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Fviihataradunih (80%) | Xybp (ohoo) | XAAh YAAa | Xybp (ohoo) | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | LlarrabaaN 3oxnra | Akknurara 3oRCooX | Xybp (ohoo) | Xybp (ohoo) | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Ganryyirtura | M3A3RA3n | XAAh hark3ap | Xybp (ohoo) | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | TerebaNerreet gyC | 3eBtremk | XAAh YAAa | Xybp (ohoo) | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | YpBAhnhah caprinruax | Xybp (ohoo) | Xybp (ohoo) | Xybp (ohoo) | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | UllarrabaaN 3oxnra | Apniryyircach | Xybp (ohoo) | Xybp (ohoo) | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Хүснэгт 1 | Хүснэгт 2 | Хүснэгт 3 | Хүснэгт 4 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 09 | Дугаар анги | xч Б.Бат | 5 2 1 - 60 3 100 25 18 72 - 2 1 - - 100 1 500 100 59.2 10 12 81 B | Хүснэгт 5 | Хүснэгт 5 | Хүснэгт 5 | Хүснэгт 6 | Хүснэгт 7 | | | | | | | | | | | | | | | |
| | | Оноо | 12 | 10 | 7.2 | 10 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 |


ДҮГНЭСЭН:

ДАРГА, /...../
(цол, гарын үсэг)
Байгууллагын нэр

/...../
(гарын үсгийн тайлал)

Онцгой байдлын өрөнхий газрын даргын
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
туслаалын ... дугаар хавсралт

1236



..... АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

..... барилга байгууламжид гамшигаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт (төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн) хяналт шалгалт зохион байгуулсан тухай

..... оны ... сарын ...-ны өдөр

..... сум, хот

Нэг. Удирдлага, зохион байгуулалт

Монгол Улсын Шадар сайдын оны дүгээр сарын-ны өдөр баталсан “Зах худалдааны төвийн барилга байгууламжид гамшигаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамж”, ... аймгийн Онцгой байдлын газрын даргын баталсан “... төлөвлөгөө, хуваарь“-ийн дагуу Гамшигаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөт (төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн) хяналт шалгалтыг оны ... дугаар сарын ... -ны өдрүүдэд дараах бүрэлдэхүүн зохион байгуулан ажиллалаа.

Үүнд:

.....аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын гамшигаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч.....

Мөн газрын гамшигаас хамгаалах улсын хяналтын байцаагч нарын нийт алба хаагч хяналт шалгалтыг зохион байгуулсан.

Хоёр. Хяналт шалгалтын талаар

Хяналт шалгалтад аймаг, нийслэлийн ... дүүргийн хэмжээнд “.....” чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт ... байгууллагад гамшигаас хамгаалах хяналт шалгалтыг зохион байгуулж ... зөрчлийг илрүүлж, ... зөрчлийг газар дээр нь арилгуулж, албан шаардлага – ..., мэдэгдэл – ..., танилцуулга – ..., акт – ..., зөвлөмж – ..., дүгнэлт – ..., -ыг гаргаж, ... иргэн, хуулийн этгээдийг ... нэгжээр торгосон.

2.1.Тоон үзүүлэлтийн талаар:

| д/д | Аймаг, нийслэлийн ОБГ | Тоон үзүүлэлт | | | | | | | | | |
|-----|--|---------------|---|---|---|---|---|---|---|---|----|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | аймгийн Онцгой байдлын газар | - | - | - | - | - | - | - | - | - | - |

2.2.Шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлийн талаар:

2.2.1.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлээгүй -00

2.2.2.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй-00

Гурав. Хүрсэн үр дүн, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт:

Илтгэх хуудсанд хавсралтаар холбогдох судалгаа, шалгалтын явц байдлын талаарх баримтжуулсан гэрэл зургийг хавсаргав.

Хавсралт 1. Шалгалтад хамрагдсан байгууллагын мэдээлэл

Хавсралт 2. Шалгалтын явц байдлыг гэрэл зураг (хуудасны тоо ...)

ТАНИЛЦСАН:

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА /гарын үсэг, тамга/

Б.БАТ

ХЯНАСАН:

ГАЗРЫН ОРЛОГЧ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАСГИЙН
ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Б.БОЛД

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
ХОШУУЧ /гарын үсэг, тэмдэг/

Б.ДОРЖ